

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн XVI хуралдаан хуралдаж 6 асуудал хэлэлцэн 6 тогтоол баталлаа. Үүнд:

- Аймгийн 2016 оны тодотгосон төсвийг хэлэлцээд 2016 оны тодотгосон төсвийн орлого, зарлага тус бүрийг 66006200.4 мянган төгрөг байхаар тогтоолоо.
- Аймгийн тусгай сангийн орлого зарлагыг батлах тухай хэлэлцээд орлогыг 3499030.8 мянган төгрөг, зарлагыг 3499030.8 мянган төгрөгөөр тус тус баталлаа.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 47 тоот тогтоолоор батлагдсан “Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт орууллаа
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн 2015 оны ажлын тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж дүгнэлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж, 10 гаруй асуудал хэлэлцэн 15 тогтоол баталлаа. Үүнд:

- Аймгийн нутаг дэвсгэрээс 2016 онд ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр агнуурын бүс нутгийн хамт тогтоолоо.
- Боловсролын байгууллагад 40 гаруй жил үр бүтээлтэй ажилласан Бадамын Өөдөсийг Монгол улсын Гавьяат багш цол, Монголын газар тариалангийн үйлдвэрлэлийн амжилт бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монголын Үндэсний Радиогийн “Ургацын далай” нэвтрүүлгийн хөтөлгөч, редактор, хэл бичгийн ухааны доктор Лханаагийн Мөнхтөрийг Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн цолоор шагнуулахаар тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.
- Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа Буддын шашны “Чойжорпэлжайлин” хийд, мөн сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Хөтөл Адвентист” сүм, Баянгол суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Эзний давалгаа” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгалаа.
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Соёлын төвийг тус сумын уугуул, Урлагийн Гавьяат зүтгэлтэн Навааны Цэрэнпилийн нэрэмжит болголоо.
- Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар бүрэн дунд сургууль үүсч байгуулагдсаны 90 жилийн ойг 2016 оны 09 дүгээр сард тэмдэглэхийг зөвшөөрлөө.
- Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Жавхлант сумын ахмад настан, “Жавхлант буудай” ХХК-ийн зөвлөх Доржийн Агваанбалганыг Монгол Улсын Гавьяат агрономич цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.
- Зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6-аас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 35 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 297 эхийг Алдарт эхийн II одонгоор тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм”-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.
- Зууны манлай хилчин, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч, онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Түүхийн ухааны доктор, дэслэгч генерал Базарын Цэдэн-Ишийн байгуулсан гавъяа зүтгэл, эх оронч, хөдөлмөрч чанарыг нь залуу хойч үедээ үлгэр дуурайлал болгон мөнхжүүлэх зорилгоор Хилийн 0243 дугаар ангийг Базарын Цэдэн-Ишийн нэрэмжит болгохоор тогтоолоо.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 92.6 хувийн гүйцэтгэлтэйгээр “Хангалттай” гэж үнэлэгдлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг иргэд, олон нийтэд мэдээлж, тайлагнахаар үүрэг болгосны дагуу 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс аймгийн Засаг дарга сумдад ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх эмхтгэлийг бэлтгэж, иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Сэлэнгэ аймгийн “Эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 2016-2026 онд 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлууллаа.

Аймгийн “Өргөн Сэлэнгэ” сонины 03 дугаар сарын дугаарын эхийг бэлтгэж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Буриад Улсын Хиагтын районд зохион байгуулагдсан “Төмс, хүнсний ногоо тариалах технологи сургалт”-нд Ерөө, Шаамар, Сүхбаатар сумдын 25 иргэнийг оролцуулж, хүнсний ногооны шинэ сортын чиглэлээр мэдээлэл өгч, 10 төрлийн 50 сортын хүнсний ногооны үрийг санал болголоо.

Жил бүр Монгол цэргийн баярыг угтан уламжлал болон зохион байгуулдаг “Би эр хүн” кроссын тэмцээнийг зохион байгуулж, өсвөрийн 5 баг, насанд хүрэгчдийн 3 баг оролцон 20, 10 км-ын зайд уралдаж 0101–р анги тэргүүлэн, өсвөрийн тэмцээнд Алтанбулаг сумын баг тамирчид 3 жил дараалан түрүүлж хошой аварга болж шилжин явах цомоо хадгалж үлдлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь улсын нөөцийн газраас манай аймагт 300 тонн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 3 дугаар сарын 14-нөөс эхлэн иргэдэд олголоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрийн газартай хамтран 4 талт түншлэлийг чадавхижуулах сургалтыг 3 удаа зохион байгууллаа.

Нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын 2015 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “Хангалттай сайн” үнэлгээ авсан 12 байгууллагын нийт 99 албан хаагчид аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгогдлоо.

Аймгийн хэмжээний төрийн захиргааны албан хаагчдын сул орон тооны захиалгыг авч нэгтгэн нийт 16 ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлснээр 2016 оны 3 дугаар сарын 14-25-ны өдрийг хүртэл нөөцөөс нөхөх арга хэмжээг зохион байгуулж Номгон томгоны Захирагчийн албаны газрын даамал, Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд 3 хүн бүртгүүлж Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн 2 хүнийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлэхээр тогтлоо.

мэдээллээр ажиллах дадлага сургуульд хэрхэн оролцох, ажлын байр, гэр орноос аюулгүй цэгт хэрхэн шилжин байрших талаар мэдээлэл өглөө.

2. Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Стандартын мэдээллийг олон нийтэд хүргэх түгээх ажлын хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сум, Дулаанхаан тосгонд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарт зориулсан шинээр батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин Ерөнхий шаардлага MNS 6558:2015” стандартаар “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад мөрдөх стандартын тухай” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сүхбаатар, Сайхан, Хүдэр, Алтанбулаг сумын 12 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумдын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан 6 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Мандал, Сайхан, Ерөө сумын 5 аж ахуйн нэгж, иргэний 16 бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргалаа. Стандартын салбар сангаас 11 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 62 нэрийн 68 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүллээ.

Худалдаа, эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа 25 жинг шалган баталгаажуулж, Ус цаг уур орчны шинжилгээний алба, 2 эмийн сангийн 11 ширхэг туухай, 3 электрон жинд шалгалт тохируулга /калибровка/ хийлээ.

Сүхбаатар сумын аж ахуйн нэгжийн усны тоолуур баталгаажуулах ажлыг “Урсгал ус” ОНӨААТҮГ-тай хамтран гүйцэтгэж, 51 ширхэг усны тоолуур шалгалтанд хамруулж, 48 ширхэг усны тоолуурт баталгаажуулалтын гэрчилгээ олгон, 3 тоолуур ашиглалтын шаардлага хангахгүй тул ашиглахгүй байх улсын шалгагчийн мэдэгдэл өглөө.

Сүхбаатар сумын 1, 5, 8 дугаар багийн айл өрхийн нэг фазын тоолуур шалгах, баталгаажуулах ажлыг гүйцэтгэж 300 гаруй цахилгааны тоолуур шалган баталгаажуулаад байна.

3. Мэргэжлийн хяналтын газар:

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2016 оны 3 дугаар сарыг “Эмийн зохистой хэрэглээг хангах, нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх сар” болгон зарлаж, 11 ажил, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын 8 дугаар зөвлөгөөнийг 2016 оны 3 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулж, сумдын улсын байцаагчдын 2015 оны ажлын тайлан, үр дүнг хэлэлцэн, сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчидтай хариуцлагын гурвалсан гэрээг байгууллаа.

“Эмийн зохистой хэрэглээ” сарын аяны хүрээнд “Чанартай эм-Зохистой хэрэглээ” сэдэвт хэлэлцүүлгийг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, “Эм” холбоотой хамтран зохион байгууллаа.

2016 оны 3дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумд, Дулаанхаан тосгонд мэргэжлийн хяналтын байцаагчдын шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ, тандалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Нэгдсэн шалгалтанд 64, зөвлөн туслах үйлчилгээнд 49 хуулийн этгээд, 298 иргэнийг хамруулж, хяналт шалгалтын явцад 368 зөрчил илрүүлж, тэдгээрийг арилгуулахаар 28 албан шаардлага, 29 зөвлөмж, 4 дүгнэлт үйлдэж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 1374,0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа.

Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 15 аж ахуйн нэгжийн 21 дээжинд 53 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд эрүүл ахуйн стандартын шаардлага хангаагүй дээж, үзүүлэлт илрээгүй болно.

4. Архивын талаар:

2016 оны 3 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд Төрийн архивын сан хөмрөгийн баримтанд нэгдсэн тооллогын ажлыг зохион байгуулж, тооллогонд нийт 126 хөмрөгийн 30540 хадгаламжийн нэгжийг хамруулан, тооллогын мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсрууллаа.

Хууль зүйн сайдын 2016 оны А/43 тоот тушаалын дагуу Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх тухай аймгийн Засаг даргын 2016 оны А/79 тоот захирамж, улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

Архивын ерөнхий газарт зохион байгуулдаг мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтын захиалгын дагуу Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сумын ерөнхий боловсролын сургууль, Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын архив, бичиг хэргийн эрхлэгч нарыг “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй” сэдэвт сургалтанд хамруулахад дэмжлэг үзүүллээ.

Төрийн архивын AMS программд шинээр хөмрөг үүсгэх нийт 25 байгууллагын жагсаалтыг гаргаж холбогдох байгууллага, сум, албан газарт цахим хэлбэрт шилжүүлэх баримтын судалгаа болон байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг ирүүлэх тухай мэдэгдлээ.

Мастер хувь үүсгэх ажлын хүрээнд Шаамарын тэжээлийн аж ахуй, сумдын Худалдаа бэлтгэлийн ангийн нийт 43 хадгаламжийн нэгжийн 3373 хуудас баримтыг скайнердаж ашиглалтын хувь үүсгэлээ. Мөн ашиглалтын хувиас Шаамарын тэжээлийн аж ахуйн 49 хадгаламжийн нэгжийн 8999 хуудас баримтыг Photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэдэд улсад ажилласан жилийн архивын хуулбар 244, магадлагаа, тодорхойлолт 33, цалингийн тодорхойлолт 8, эхийн одонгийн лавлагаа 2 гаргаж үйлчиллээ.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

2-р сарын 28-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|--|--------------|-------------|-------|
| Орон нутгийн төсвийн нийт орлого | 2,320,594.9 | 2,001,467.9 | 86.2 |
| Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 1,807,232.3 | 1,677,623.9 | 92.8 |
| Орон нутгийн төсвийн нийт зарлага | 10,137,258.1 | 8,772,573.4 | 86.5 |
| Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн | 1,394,524.1 | 989,302.9 | 70.9 |
| -Аймгийн ОНХСангийн зарцуулалт | 220,859.0 | 91,944.1 | 41.6 |
| -Аймгийн авто замын хөрөнгө оруулалт | 60,995.6 | 60,985.6 | 100.0 |
| -Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | - | - | 0.0 |
| Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг | 322,147.7 | 174,999.6 | 54.3 |
| Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг | 796,740.0 | 796,740.0 | 100.0 |
| Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 7,132,808.4 | 7,303,627.8 | 102.4 |
| - Ерөнхий боловсролын сургууль | 3,577,218.3 | 3,748,037.7 | 104.8 |
| - Хүүхдийн цэцэрлэг | 1,895,000.4 | 1,895,000.4 | 100.0 |
| - Эрүүл мэнд, спортын байгууллага | 1,048,515.5 | 1,048,515.5 | 100.0 |
| - Соёлын байгууллагуудын | 524,493.2 | 524,493.2 | 100.0 |
| - Газрын харилцаа кадастрын алба | 36,182.1 | 36,182.1 | 100.0 |

| | | | |
|--|-------------|-------------|-------|
| - Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс | 51,398.9 | 51,398.9 | 100.0 |
| Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 7,132,808.4 | 7,132,808.4 | 100.0 |
| - Ерөнхий боловсролын сургууль | 3,577,218.3 | 3,577,218.3 | 100.0 |
| - Хүүхдийн цэцэрлэг | 1,895,000.4 | 1,895,000.4 | 100.0 |
| - Эрүүл мэнд, спортын байгууллага | 804,504.6 | 804,504.6 | 100.0 |
| - Соёлын байгууллагуудын | 524,493.2 | 524,493.2 | 100.0 |
| - Газрын харилцаа кадастрын алба | 36,182.1 | 36,182.1 | 100.0 |
| - Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс | 51,398.9 | 51,398.9 | 100.0 |
| Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 193,288.7 | 105,000.0 | 54.3 |
| Аймгийн нийт нөөц хөрөнгө гүйцэтгэл | 120,545.7 | 83,143.5 | 69.0 |
| Үүнээс Аймгийн Засаг даргын нөөц | 75,000.0 | 42,664.4 | 56.9 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | | 2016 II- сар | 2016 III- сар | <u>2016-II</u> <u>2016-III</u> |
|-------------------------------------|--------------------------------------|--------------|---------------|-----------------------------------|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | | |
| 1 | Талх, гурил, будаа | | | |
| | Гурил /савласан, кг/ | 1200 | 1200 | 100 |
| | Талх /орон нутгийн, ш/ | 1100 | 1100 | 100 |
| | Нарийн боов /кг/ | 2300 | 2300 | 100 |
| | Будаа /кг/ | 2200 | 2200 | 100 |
| | Элсэн чихэр /кг/ | 1800 | 1800 | 100 |
| 2 | МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | | | |
| | Хонины мах /кг/ | 4500 | 5000 | 111.1 |
| | Үхрийн мах /кг/ | 5500 | 6000 | 109.1 |
| | Адууны мах /кг/ | 4000 | 4000 | 100.0 |
| | Ямааны мах /кг/ | 3500 | 4000 | 114.3 |
| | Дотор мах, цувдай /цусгүй/ | 3500 | 3500 | 100.0 |
| | Хиам /чанасан, кг/ | 9500 | 9500 | 100.0 |
| 3 | СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | | | |
| | Сүү /задгай, л/ | 1300 | 1300 | 100 |
| | Сүү / савласан, л/ | 2500 | 2500 | 100 |
| | Тараг /задгай, л/ | 1500 | 1500 | 100 |
| | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 10000 | 10000 | 100 |
| | Айраг /л/ | 3500 | 3500 | 100 |
| | Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 4000 | 4000 | 100 |
| | Өндөг /ш/ | 300 | 300 | 100 |
| 4 | БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС | | | |
| | Ургамлын тос /л/ | 3400 | 3400 | 100 |
| | Өөхөн тос /кг/ | 1500 | 1500 | 100 |
| | Шар тос /кг/ | 9000 | 9000 | 100 |
| | Масло /задгай, кг/ | 5000 | 5000 | 100 |
| 5 | ХҮНСНИЙ НОГОО | | | |
| | Төмс /кг/ | 1000 | 1000 | 100 |
| | Лууван /кг/ | 1800 | 2000 | 111 |
| | Манжин /кг/ | 2000 | 2000 | 100 |

| | | | | |
|----------|-------------------------------------|------|------|-------|
| | Байцаа /кг/ | 1500 | 2000 | 133 |
| | Сонгино /кг/ | 2000 | 2000 | 100 |
| | Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 3000 | 3000 | 100 |
| | Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/ | 2500 | 2500 | 100 |
| 2 | ШАТАХУУН | | | |
| | Бензин А - 80 | 1480 | 1480 | 100.0 |
| | Бензин А - 92 | 1580 | 1580 | 100.0 |
| | Дизелийн түлш | 1690 | 1690 | 100.0 |

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн зорилт, ээлжит хичээлийн уялдаа холбоозорилгод хүрч буй эсэхийг ажиглах, сайжруулах зорилгоор Хараа, Бэлчир бүсийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт сургалт зохион байгуулж нийт 18 сургуулийн 400 гаруй багш, сургалтын менежер хамрагдлаа.

“Зөв Монгол хүүхэд хөтөлбөр-хүүхэд бүрийн хөгжилд” эссэ бичвэрийн аймгийн уралдааныг зохион байгуулж, дүнг нэгтгэн БСШУЯ-ны стратегийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүллээ.

“Хүүхэд бүрийг хөгжүүлэх сайн хичээл, үйл ажиллагаа удирдамж”-ийн дагуу бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 153 багш, сургалтын менежер хамрагдлаа.

2015-2016 оны хичээлийн жилд улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 13 хичээл, 53 ангиллаар зохион байгууллаа.

“Залуу зохион бүтээгч 2016” уралдааны орон нутгийн урьдчилсан шалгаруулалтыг зохион байгуулж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуулийн 4 бүтээлийг шалгаруулж, МҮОНТ-ийн нэвтрүүлэгт оролцуулан 10 сурагчийн 4 бүтээлийн санаа тэнцэж дараагийн шатанд оролцох эрэхтэй боллоо.

Техник загварын “Формула” тэмцээнийг Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын 4-р сургуультай хамтран зохион байгуулж 10 сургуулийн 20 загвар оролцож багийн дүнгээр Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль тэргүүллээ.

“Багшаар ажиллах эрх олгох шалгалт”-ыг зохион байгуулж шалгалтанд 55 хүн бүртгүүлж 32 шалгуулагч тэнцэж, тайланг Багшийн мэргэшил дээшлүүлэх институтад хүргүүллээ.

2. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:

Баянгол суманд даамны аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг зохион байгуулж, Сүхбаатар, Мандал Баянгол, Сайхан, Цагааннуур сумаас нийт 130 гаруй тамирчид оролцон багийн дүнгээр Сайхан сумын баг тамирчид тэргүүллээ.

Мандал суманд Волейболын аймгийн аварга шалгаруулах идэрчүүдийн тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй багуудаас Мандал сумын 3-р сургууль спорт сургуулийн багууд эхний гурван байранд шалгарсан болэмэгтэй баг тамирчдаас аймгийн спорт сургууль, Мандал сумын 1-р сургууль, Мандал сумын 3-р сургуулийн баг тамирчид эхний байранд шалгарлаа.

МҮОНРТ-ын нэрэмжит өсвөр үеийн Гандболын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Баянгол суманд зохион байгуулж, тэмцээнд Улаанбаатар хот, Дархан, Булган, Дорноговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн 14 байгууллагын 36 багийн 400 гаруй тамирчид оролцлоо.

Эрүүл мэндийн салбарын шинэ сувилагчдыг чадавхижуулах онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн салбарын 25 сувилагчид хамрагдлаа.

3. Нийгмийн даатгалын талаар:

Нийгмийн даатгалын санд 3713.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 3909.7 сая төгрөг хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 105.5 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 14709 тэтгэвэр авагчдад 7927.7 сая төгрөгийг олгож, тэтгэмжийн даатгалын сангаас 863 даатгуулагчдад 261.7 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болонамаржсаны, оршуулгын тэтгэмж олголоо.

Үйлдвэрлэлийн осол мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 237 даатгуулагчид 180.6 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувилалын зардалд олголоо.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 130 даатгуулагчдад 118.8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг эмийн сангуудад 788.0 сая төгрөгийн эмчилгээний болон эмийн үнийн хөнгөлөлт тус тус олголоо.

4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2016 оны 2 дугаар сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 816 байсан бол 152 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 46 ажлын байранд 19 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 75 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 874 боллоо.

Монгол Улсын Хөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулсан “БНСУ-д ажилчид илгээх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд 12 дахь удаагийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 2016 оны 3 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд зохион байгуулж, 93 эмэгтэй, 330 эрэгтэй болон нийт 423 иргэний бүртгэлийг хийлээ.

Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Хөдөлмөрийн харилцаа болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, “Урсгал Ус” ОНӨААТҮГ-ын ажилтан албан хаагчдад Хөдөлмөрийн болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт зохион байгууллаа.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-ийн Сэлэнгэ салбарын ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

5. Хүүхэд залуучуудын талаар:

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхэмлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор гэрлэж буй хосуудад гэрлэлтийн баталгаа гардуулах, гэр бүлийн тангараг өргүүлэх үйл ажиллагааг “Хүндэтгэлийн танхим”-д зохион байгуулж байна.

Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийн 2 дахь шатны сургалтыг зохион байгуулж нийт 44 хүн хамрагдаж 34 хүн сертификат авах эрхтэй боллоо.

“Би эстрадын дуучин 2016” аймгийн аварга шалгаруулах уралдааныг Сайхан суманд зохион байгуулж, нийт 52 сурагч оролцож шалгарсан сурагчид улсын уралдаанд оролцох эрхээ авлаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Сэтгэлийн дэм4” аяныг “Таны тус-төлийн дуу” уриатайгаар аймгийн хэмжээнд өрнүүллээ.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын бүрэн дунд 35 сургуульд “School police” эцэг эхийн эргүүлийн журмын төслийг хүргүүлэн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хүсэлтийг авч нэгтгэн, нийт 8042 эцэг эх дэмжлээ.

Тав.Хүнс, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг өөрийн аймгийн онцлогт тохируулан боловсруулах ажлыг хийж байна.

2015 оны ургацаас гурилын үйлдвэр болон Тариалан эрхлэгчдийг дэмжих санд тушаасан улаанбуудайн урамшуулалд энэ онд 149 аж ахуйн нэгж, 51 иргэдийн 40.0 мянган тн буудай урамшууллын материалыг сумдаас хүлээн авч, Хүнс, хөдөө аж ахуйн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр “Аймгийн ногоочдод үнэмлэх олгох журам”-ыг боловсрууллаа.

Аймгийнхаврын хэрэгцээт нөөцийн махыг үнийнхэтэсөлтийгхязгаарлах, хямдүнэтэймахыгзахзээлднийлүүлэхзорилгоор03 дугаар сарын 01-нээс Сүхбаатар сумын 7-р багийн “Бөмбөөлэй”, “Шонхор”, “Аян”, “Мандах наран”, “Өнхрүүш”, “Ариун”, “Замбаалай”, “Гурванбулаг”, “Хүлэг”, “Итгэлт” хүнсний дэлгүүрээр нөөцийн махыг 1кг-ийг нь 4200 төгрөгөөр худалдан борлуулах ажлыг зохион байгууллаа.

Энэ онд манай аймагт 676912 эх мал төллөхөөс 03 дугаар сарын 24-ний байдлаар 78863 эх мал төллөж, үүнээс ингэ 3, гүү 262, үнээ 4061, эм хонь 40363, эм ямаа 30574 төллөж, төл бойжилт 98.8 хувьтай нийт мал төлөлт 7.8 хувьтай байна.Том малын хорогдол нийт 956 үүнээс адуу 81, үхэр 229, хонь 312, ямаа 334 үүнээс хээлтэгч 258, өвчнөөр 79 бусад нь зүй бусаар хорогдсон мэдээтэй байна.

Сүхбаатар, Хушаат, Цагааннуур, Мандал,Ерөө, Сайхан, Орхонтуул зэрэг сумдаас богын 3100 тун, бодын 1500 тун үрийн захиалга авч Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүлээд байна.

127 кг адууны мах, 3198 кг үхрийн мах, 1656 кг хонины мах, 75 кг ямааны мах, 257 кг гахайны мах, 320 литр сүүний дээжинд магадлан шинжилгээ хийж баталгаажуулан, гэрчилгээ олголоо.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Газрын харилцааны талаар:

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас 2016 онд газрыг олон зориулалтаар ашиглан баялаг бүтээж, үр шимийг хүртэх чиглэлийг агуулсан “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г олон нийтийн оролцоонд тулгуурлан загвар байдлаар боловсруулан, зориулалтаар нь бүртгэж, баталгаажуулах ажлыг манай аймгийн Орхон сумыг сонгон ажиллаж байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 234 тоот тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-ын дагуу1997 оны 152 тоот тогтоолоор газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлон итгэлцүүрт оруулан бодож байх талаар сумдын газрын даамлуудад чиглэл хүргүүлээ.

Баянгол, Мандал суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Бороо-гоулд ХХК, Центерра-гоулд ХХК-ийн газрын төлбөр төлөлтийн гүйцэтгэлийн судалгааг гаргалаа.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн сайдын баталсан “Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийж байна.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

2016 оны 3 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд Сайхан, Орхон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн сумдадсалбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, сумдын газрын даамлын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагч

нарт хөрөнгө оруулалтын төсөл төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл захиалах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

3. Байгаль орчны талаар:

“Дэлхийн усны өдөр”-т зориулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Урсгал Ус ОНӨААТҮГ-ууд хамтран “Дусал усны үнэ цэнэ” сэдэвт арга хэмжээг зохион байгууллаа.

БОНХАЖЯ-аас 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан зөвлөгөөнд Байгаль орчин аялал жуулчлалын газрын ажилтан албан хаагчдыг оролцууллаа.

Тус аймгийн Алтанбулаг, Мандал сумдад мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Хярааны хонхор” ХХК, “Өгөөж хараа” ХХК, “Номголжин” ХХК, “Сансар хараа” ХХК-иудад ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах дүгнэлт гаргалаа.

Ерөө суманд ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн ойн менежментийн төлөвлөгөөг хянан баталгаажууллаа.

Сумдын засаг дарга, сумын болон сум дундын ойн ангиудад тухайн суманд олгогдсон түлээний модыг гадагш тээвэрлүүлэхгүй байх талаар чиглэл өглөө.

Долоо.Сум орон нутгийн талаар:

1.Жавхлант сум:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас “Иргэдээ сонсьё” уулзалтыг зохион байгуулж, аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Цагдаагийн газраас 2015 оны үйл ажиллагааны тайлангийн талаар мэдээлэл хийж, 2016 онд баримталж ажиллах бодлого, чиглэл “Архидалттай тэмцэх” аймгийн хөтөлбөр, “Архигүй монгол” үндэсний чуулганаас гарсан зөвлөмж, замын хөдөлгөөний дүрэм, жолооны шинэ үнэмлэхний талаар иргэдэд тус тус зөвлөгөө өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн 15 зорилтот өрхийг сонгон төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины голомтын дархлаажуулалтанд 6 голомтын 54 хүнийг хамрууллаа.

Монгол Улсын тэргүүний ардын авяастан З.Баяраагийн нэрэмжит “Ардын урлагаа хөгжүүлэе” урлагийн наадмыг зохион байгуулж, төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд идэвхи санаачлагатай оролцлоо.

2016 оны хаврын тариалалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан тус сумын Засаг даргын Тамгын газар Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран газар тариалангийн болон төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан гэрээ байгуулж, тариалангийн талбайд хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэх ажлыг эхлүүлээ.

2.Зүүнбүрэн сум:

Зүүнбүрэн сумын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж эхний судалгааны мэдээллийг сумын иргэдэд танилцууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын гаргасан уриалгын дагуу олимпын хөгжлийг дэмжих сангийн “Рио-2016” цомыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар аялуулж, “Рио-2016” олимпын их наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулан тус аянд сумаараа нэгдлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, “Сэлэнгэ амьдрах сайхан” төрийн бус байгууллагатай хамтран “Хувь хүний хөгжил”, “Архины хор уршгийн талаархи сургалтыг төр, төсвийн байгууллагын ажилтан албан хаагчид болон сумын иргэдэд зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан тус сумын ерөнхий боловсролын сургуулиас “Ээждээ хэлэх миний үг” сэдэвт шилдэг захидлын уралдааныг зохион байгууллаа.

3.Ерөө сум:

Ардын хувьсгалын 94 жилийн ойн баяр наадмаар Улсын хошой мэргэн цол хүртсэн С.Энхтунгалаг, Улсын мэргэн цол хүртсэн Б.Батбаатар нарыг Ерөө сумын Засаг даргын хүсэлтээр хүүхэд, залуучуудын спортын авьяас билгийг хөгжүүлэх зорилгоор сумандаа урьж, сур харвааны сургалтыг зохион байгуулан нийт 40 гаруй иргэд хамрагдлаа.

2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн сургалтыг аймгийн Татварын хэлтэс, Ерөө сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2016 оны 03 сарын 17-ны өдөр зохион байгуулж, 90 иргэн, 20 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, 18 бизнес эрхлэгч нар хамрагдлаа.

Ерөө сумын 2-р багийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн Бямба овогтой Ганболд нь гутал засврын ажил эхлүүлэх хүсэлтэй бөгөөд уг ажлыг эхлүүлэхэд эхний ээлжинд туслах материал авах санхүүжилт хэрэгтэй байгааг харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон дэмжиж сайн үйлсийн аян зохион байгуулан санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

2016 онд тариалахаар нөөцөлсөн АчитОргил ХХК, Доолт ХХК, Их Шинэстэй ХХК, Моностойн нуруу ХХК, Цогтнэм ХХК, Агро жавхлант ХХК, Шинэ тариа ХХК, Сонсголон ньуу агро ХХК-иуд аймгийн Мэргэжлийн хяналтын газарт үрийн дээжээ шинжилгээнд хамрууллаа.

4.1 àí äàë ñòì :

Сумын “Архидан согтуурахтай тэмцэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газраас Дэлхийн Зөн Зүүнхараа орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Жаргалтай гэр бүл” сургалтыг нийт 500 иргэнийг хамруулан амжилттай зохион байгууллаа.

“Төрийн захиргааны албан хаагчдын туршлага солилцох уулзалт”-ыг зохион байгуулан сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид болон Хэрх, Түнхэл тосгоны захирагчийн албаны албан хаагчид оролцон 2015 оны үйл ажиллагааны үр дүнгээ хэлэлцэж, орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийнталаар мэдээлэл хийж харилцан туршлага солилцсон үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Зүрх сэтгэлийнхээ нандин үгсийг цаасан дээр буулгаж, захидал болгон хайртай эмээ, ээж, эгч, дүүдээ илгээх боломжийг эрхэм зорилгоо болгосон “Ижийдээ илгээх миний захидал” уралдааныг 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Уралдаанд нийт 170-аад захидал ирснээс оролцогчид маань захидлаа өөрийн биеэр уншиж, захидлын эрхэм эзэддээ гардуулсан хүндэтгэлийн үйл ажиллагаа боллоо.

Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулан сурталчлах, сум орон нутгаасаа шилдэг уран уншигчдыг төрүүлэн гаргахад чиглэгдсэн Мандал сумын аварга шалгаруулах “Уран жиргээ-2016” уран уншлагын наадмыг зохион байгуулан 4 насны ангилалд нийт 73 хүүхэд оролцож шилдгүүдээ тодрууллаа.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, сумын Засаг даргын Тамгын газар хамтран Ахмад, настан хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнд “Өдрийн үйлчилгээ”-г зохион байгуулж, Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүдтэй уулзалт өдөрлөг хийн 114 иргэн, хүүхдийг хамруулан нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулан, зөвлөгөө өгч витаминжууллаа.

5.Орхон сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж зөвлөгөөнөөр төрөөс малчдын талаар баримтлах бодлого, Монгол мал хөтөлбөрийн эхний үе шатны хэрэгжилт, 2 дахь үе шатанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, Сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Мал эмнэлгийн үйл ажиллагааны талаармэдээлэл хийн нийт 150 гаруй малчин, мал бүхий иргэдийг хамрууллаа.

Иргэдэд цаг үеийн мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын иргэдэд хүргэх зар мэдээллийг агуулсан гарын авлагыг гаргаж сумын төв, хөдөөгийн 2 багт нийт 280 өрхөд хүргэж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/28 тоот захирамжийн хүрээнд хийгддэг “Тайлан мэдээлэл, санал шийдэл” иргэдтэй уулзах өдөр арга хэмжээг 2016 оны 3 дугаар сарын 23, 24-ний өдөр зохион байгуулж, улсын бүртгэл, нийгмийн даатгал, нийгмийн бодлого хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж үйлчилгээ, байгаль орчин, хөдөө аж ахуй, төсөв санхүү, татвар болон төрийн захиргааны бусад мэдээллүүдийг хүргэж 130 гаруй иргэнийг хамрууллаа.

Тус сумын 2-р багийн нутаг Мангирт, Баюудай зэрэг газруудад зөвшөөрөлгүй бэлчээр ашигласан Баянгол, Сайхан, Хонгор сумдын 3 малчин өрхөд Газрын тухай хуулийн 63.1.8-д заасны дагуу нийт 1152.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцлоо.

6. Орхонтуул сум:

Тайлант сард сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар Хөдөө аж ахуй, Орхонтуул сум үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, сумын Соёл эдийн засгийн өдрүүд арга хэмжээг аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө, Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай сумын хөтөлбөрүүдийг хэлэлцлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Сэлэнгэ аймгийн 9 бахархал, 9 байгалийн үзэсгэлэнт газар, 9 түүх соёлын дурсгалт газрын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, Орхон-Туул хоёр голын бэлчир, Шар хадны нуруу, Түүх соёлын дурсгалт газарт Бурхантай чулуу, Хадны сүг зураг, Буган чулуу хөшөө зэрэг түүх соёлын дурсгалт зүйлсийн мэдээллийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Хонгор-Овоо 3-р багийн нутагт хяналт шалгалт хийж, шалгалтаар Булган аймгийн Орхон сумын 3 иргэн тус газарт зохих зөвшөөрөлгүй 10 гаруй жил нутаглаж бэлчээр ашиглаж байсан зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авч бэлчээр ус ашигласан төлбөр тооцоог барагдуулан зөрчлийг арилгуулан ажиллалаа. Мөн Чойжилын тохойд хяналт шалгалт хийх явцад зохих зөвшөөрөлгүй гар аргаар алт олборлож байсан 10 гаруй иргэнд Ашигт малтмалын тухай хуулийг тайлбарлан дахин гар аргаар алт олборлохгүй байх талаар үүрэг өгч ухсан нүхийг булуулах арга хэмжээг авлаа.

7. Сүхбаатар сум:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага, сургуулийг 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 16.00 цагт зохион байгуулж, сумын хэмжээнд 904 иргэн оролцлоо.

2016 оны 01 дүгээр сарын 01-ээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай шинэчилсэн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийг иргэдэд сурталчилах, хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилон, стандартын шаардлага хангасан кассын машиныг 03

дугаар сарын 20-ны дотор байршуулж ажиллахыг тус суманд үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа, үйлдвэр, үйчилгээний газруудад мэдэгдлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Архидалттай тэмцэх” аймгийн хөтөлбөрийг иргэд, төрийн албан хаагч нарт сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, гарын үсэг зуруулан баталгаажууллаа.

Дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан шар усны үерээс урьдчилан сэргийлэх, гол мөрний усаар гарахгүй байх талаар сэрэмжлүүлэг, анхааруулга, мэдээллийг иргэдэд цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.

8.Алтанбулаг сум:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Дунгийн эгшиг”, “Уран жиргээ” наадмыг зохион байгуулж, аваргуудаа шалгаруулан аймгийн наадамд оролцох сурагчдыг сонгон бэлтгэж байна.

Хүмүүнлэгийн байгууллагаас зохион байгуулсан “Бяцхан төлчин” аяныг сумандаа өрнүүлэн 300 ширхэг элгэвч ирсэний 250 ширхэгийг нь малчдад, 50 ширхэгийг нь хилийн цэргийн 0101-р ангийн малчдад илгээх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын эрүүл мэндийн төвөөс байгууллагынхаа ажилчдад “Гар угаах дараалал” арга зүйн сургалтыг зохион байгуулж, сумын нийт төр төсвийн байгууллагуудын албан хаагчдаас бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч зөвлөгөө өгсөн.

9.Цагааннуур сум:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 193 тоот тогтоолоор батлагдсан Улсын тэргүүний сум шалгаруулах болзлын дагуу тайлан мэдээллийг бэлтгэн хүргүүлээ.

Зуны спортын 31 дэх удаагийн Рио–2016 наадамд оролцох тамирчидаа дэмжих зорилгоор аймаг, сум орон нутгаар аялуулж буй Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит “РИО-2016” цом, дэвтрийг 2016 оны 03 сарын 09-нд Зүүнбүрэн сумын удирдлагуудад хүлээлгэн өгч, сумын төр төсвийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээр аялуулан 400 гаруй мянган төгрөгийг олимпийн хөгжлийг дэмжих санд төвлөрүүлж Түшиг суманд хүлээлгэн өглөө.

Сумын Засаг даргын захирамжаар баталсан сумын “Урлаг спортын нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төвөөс хамтран “Авьяаслаг Цагааннуурчууд” тэмцээнийг зохион байгуулан 5 авьяастаныг шилдгээр шалгарууллаа. “Авьяаслаг Цагааннуурчууд” тэмцээнийг Улсын тэргүүний тариаланч хамт олон Товхонхан ХХК, Ургацын хишиг ХХК, Улсын сайн малчин М.Пүрэвжав нар ивээн тэтгэлээ.

10.Хушаат сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас "Малчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж малчдад "Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт", "Бэлчээр ашиглалт хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилт, анхаарах зүйлс", "Мал үржлийн ажлын ололт амжилт, анхаарах зүйлс", "Малын эрүүл мэндийг хамгаалах асуудал, зорилт", "Тариалангийн бүсэд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх онцлог" зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгөн, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар иргэдийн санал хүсэлтийг сонсон цаашид баримтлан ажиллах уриалгыг гаргалаа.

Олон улсын Улаан хавирган сар байгууллага, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Онцгой байдлын газар, Амьтдыг хамгаалах нийгэмлэг хамтран тус сумын 30 өрхөд хүмүүнлэгийн тусламжийг үзүүллээ.

2016 оны аймгийн аварга шалгаруулах ахмад шатарчдын тэмцээн" -ийг аймгийн Шатрын холбоо, Биеийн тамир спортын газар, Ахмадын хороо, Хушаат

сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж, 8 сумын 50 гаруй тамирчид оролцлоо.

11.Хүдэр сум:

Сумын “Иргэдийн эрх зүйн боловсрол”-ыг дээшлүүлэх бодлогын зорилтын хүрээнд Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, галт зэвсгийн татварын тухай хуулиар аймгийн Цагдаагийн газар, суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн талаар сумын Засаг даргын Тамгын газраас тус тус 48 иргэнд сургалт зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан ахмад настнуудын дунд “Ээж бүхэн сайхан” уриан дор цэнгүүн зохион байгуулж, 68 ахмад настан хамрагдлаа.

Аймгийн төрийн архивт шилжүүлэхээр 1976-1990 оны 41 баримтыг сэлбэн засаж, эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийлээ.

Тус сумын Цэцэрлэгээс багш, туслах багш нарын дунд “Мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлэх” аяныг 2 үе шаттай хэрэгжүүлэн, багш, бүрцахим шуудантай болж, харилцан мэдээлэл солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээлэлийн сүлжээ байгуулж, харилцан туршлага солилцож байна.

12.Шаамар сум:

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус сумын Эрүүл мэндийн төвөөс нийт сумын эмэгтэйчүүдийн дунд гар, бөмбөг, аэробекийн тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж, төр төсвийн байгууллагын эмэгтэй ажилтан, албан хаагч, иргэд идэвхитэй оролцлоо.

Тус сумын хэмжээнд бог малын төллөлт 45 хувьтай бод малын төллөлт 40 орчим хувьтай байна. Ашиг шим өндөртэй Хангай үүлдрийн мах ноосны төл болон Үзэмчин омгийн мах өөхний чиглэлийн хонины төллөлт хэвийн гарал угшилаа даган гарч байна.

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн НӨАТ-ын урамшууллын хуулийг хэрэгжүүлэн ажиллаж сумын Засаг даргын захирамжаар ажлыг хэсэг байгууан аж ахуйн нэгж, иргэдэд сургалт сурталчилгааг зохион байгууллаа.

13.Түшиг сум:

Тайлант сард сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 30 дугаар хуралдаанаар хэлэлцэж, 92.4 хувийн гүйцэтгэлтэйгээр “Хангалттай” үнэлгээ өглөө.

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 115 тоот тогтоолоор “Гэр бүлийн өдөр”-тэй болохоор шийдвэрлэлээ.

Сумын Засаг даргын 2016 оны А/11 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 6 ажлын хэсэгт томилогдон нийт 216 айл өрхөд мэдээлэл хийн, гарын авлага тараалаа.

Архигүй орчин аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 1-3 дугаар ангийн сурагчдын дунд АХА тэмцээн ахлах ангийн сурагчдын дунд цагдаагийн хэсгээс архины хор уршигийн талаар мэдээлэл хийлээ.

Сумын улсын бүртгэгчээс 1999 оны 01 дүгээр сарын 01-ээс 2010 оны 12 дугаар сарын 30-ны хооронд төрсөн хүүхдийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн сантай тулган шалгаж нийт 457 хүүхдээс 85 хүүхдийн бичиг баримт зөрчилтэй байсныг залрууллаа.

14.Баянгол сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын хэлтсээс цаг агаар болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан гарах гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх гарсан тохиолдолд хугацаа алдалгүй мэргэжлийн байгууллагуудад мэдээлэн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг бэлэн байлгах талаар сумын төр төсвийн байгууллагуудад үүрэг чиглэл өгч сэрэмжлүүлэг, цаг агаарын урьдчилсан мэдээг иргэдэд шуурхай мэдээлэн ажиллаж байна.

Тус суманд Монгол Улсын харьшгүй мэргэн А.Доржсүрэнгийн нэрэмжит шагайн харваа тэмцээн зохион байгуулагдаж, нийт 27 баг тамирчид өрсөлдөж Булган аймгийн тамирчид тэргүүлж, Говь-Алтай аймгийн баг тамирчид удааллаа.

Сумын Засаг даргын 2016 оны А/32 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдолтой тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

2016 оны 3 дугаар сарын 3-ны өдөр тус сумын Хараа багийн Өлийн шанд орчмын зам хаагдсан тул хаваржилт хүндэрч, өвс тэжээл нь дууссан айл өрхөд 80 боодол өвс, 120 кг будааг хүргэж өглөө.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР